



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Сайншанд сум 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Т.Оюунтуяа Утас: 99048991 Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.25 № 16/175

танай _____-ны № _____-т

УЛААНБАДРАХ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Г.ЧИМЭДРЭГЗЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	63.6	129.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	340.5	366.9
	Нийт хөрөнгийн дүн	404.1	496.6
	Нийт өр төлбөрийн дүн	0.1	13.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	404.0	483.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	404.1	496.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	369.3	654.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	356.1	491.3
	Үйл ажиллагааны үр дүн	13.2	163.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	(84.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	13.2	79.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	404.0	404.0
	Тайлант оны үр дүн	96.1	79.3
	Эцсийн үлдэгдэл	404.0	483.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	331.2	395.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	323.5	393.9
	Үйл ажиллагааны ЦМГ	7.7	1.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(2.8)	(0.8)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	4.9	0.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	346.1	341.9
	Урсгал зардал	346.1	341.9
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	346.1	342.1
	Улсын төсвөөс санхүүжих	306.8	306.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24.3	22.9
	НД-ын сангийн төсвөөс санхүүжих	14.9	12.4

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны чиглэлээ “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт сэтгэл ханамжтай, чанартай, хүртээмжтэй хүргэх, хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулах, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудит болон аудитор байхгүй.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 348.8 сая төгрөгийн 21 орлогын гүйлгээ, 7.0 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39.4 сая төгрөгийн 5 худалдан авалтын гүйлгээг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 7 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 104.9 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39.4 сая төгрөгийн худалдан авалтын 5 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7.0 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн журналаас үлдэх өртгийн эхний үлдэгдлийн дүн 0.1 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийн дүн 6.4 сая төгрөгөөр зөрүүтэй. Ашиглалтын хугацаа тавигдаагүй 10 ш, 21.7 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцсоныг;
2. Санхүү байдлын тайланд ХХОАТ-ын бодит бус өр 4.8 сая төгрөг, татварын тодорхойлолтоор 0.7 сая төгрөгийн өртэй алдаатай бүртгэснийг залруулав.

Албан шаардлага

1. Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын 2101 тоот дансанд ажил олгогчоос төлөх НДШ-ийн 0.7 сая төгрөг, 2102 тоот дансанд цалингаас суутгасан НДШ-ийн 4.8 сая төгрөг, 210901 тоот дансанд сургалтын төлбөрийн 0.2 сая төгрөгийг эдийн засгийн ангилал зөрүүтэй бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай”, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай 2021 оны 190 тоот батлагдсан тушаалыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллагын Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 104.9 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39.4 сая төгрөгийн худалдан авалтын 5 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7.0 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-т Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “...орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр,...” тус тус мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал:

- 1.1. *Илрүүлэлт:* 2021 онд аж ахуйн нэгж байгууллагуудаас и-баримтгүй 7.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т “төлбөрийн баримт” гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг

1.2. **Өгсөн зөвлөмж:** Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	+	+			+			
НИЙТ									

/сая төгрөгөөр/

[illegible]